

09 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Төрийн үйлчилгээний чиглэлээр: ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж баталгаажуулалтын гэрчилгээг МонСертф ХХК-ы гардан авлаа. Мөнххаан – Алтан намар -2022 үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Шилдэгээр шалгарсан баялаг бүтээгчид аймгийн Үзэсгэлэн худалдаанд оролцоно Уг үйл ажиллагааг зохион байгуулахад Засаг даргын нөөц сангаас 1,5 сая төгрөгийн санхүүжилт олгов. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд 2022.09.25-ны өдөр ажиллаж цаг үеийн байдал, Өвөлжилт хаваржилтын бэлтгэл бэлэн байдал, Улс аймаг сум Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалттай танилцаж сумын иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийв.

Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд**Нийгмийн халамж:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр 114 иргэнд 3,193,420 төгрөг

Нийгмийн халамжийн тэтгэмж 114 иргэнд 11,800,583 төгрөг

“Цалинтай ээж”-ийн тэтгэмж 273 иргэнд 13,187,156 төгрөг

Жирэмсэн эхийн тэтгэмж 26 иргэнд 1,003,272 төгрөг

Ахмад настны хөнгөлөлт -1 иргэнд 130000 төгрөг

Хүүхдийн мөнгө 1737 хүүхдэд 173,700,000 төгрөгийн олголт хийгдсэн байна.

ХЭБҮ-нд энэ сард 32 өрхийн 149 иргэний 1744,0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эрдэнэцагаан суманд чадавхижуулах сургалт болон Туршлага судлах ажлаар 2 хоног явсан.

Бүлгээр хүнсний ногоо тариалдаг зорилтот бүлгийн эмэгтэйчүүд “Мөнххаан-Алтан намар-2022” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож “Төмс, хүнсний ногоо жимс, жимсгэнэ” төрөлд 2-р байр эзэлсэн. 230000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ХХҮГазрын Захиргаа хяналтын хэлтэсийн дарга М.Мөнхзул ажлын явцтай танилцаж ХЭБҮ-ний 4 өрхийг зогсоож, санхүүгийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэлттэй 4 өрхөөр явж энэ оны 12 сарын 31нд төлж дуусгахаар мэдэгдэл өгч, хугацаандаа төлөөгүй нөхцөлд дараагийн шатны шүүхэд өгөхөөр мэдэгдлээ.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Эрүүл мэндийн даатгалд 26 иргэн даатгуулсан. Сайн дурын даатгалд шинээр 2 иргэн хамрагдсан. Мөн өндөр насны тэтгэвэр авагч 8 иргэн банкаа солих хүсэлт өгч хүсэлтийг баталгаажуулсан. Группын тэтгэвэр авагч 4 иргэн группээ сунгуулж тэтгэврийг нөхөн олгов. Шинээр өндөр насны тэтгэвэр 3 иргэний материалын хүлээн авсан. 0-3 хүртэлх насны эх шинээр 1 эх даатгуулсан. 9 сарын 5 нд бойны газар ажилчдад мэдээлэл хийж ажилласан. 11 иргэн хамрагдсан. 9 сарын 14- 19 ны өдрүүдэд багуудын хурал болж баг дээр иргэдэд мэдээ мэдээлэл хуулийн хэрэгжилтын талаар мэдэлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

ЕБС

1. Манай байгууллага нь энэ хичээлийн жилд 91 багш, ажилчид, 1015 суралцагчтай үйл ажиллагаа явуулж байна.

2. Сүхбаатар аймгийн Засаг даргын 06 дугаар албан даалгавар, Мөнххаан сумын Засаг даргын А/136 дугаар захирамжийн дагуу Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс 25тн нүүрс нөөцөлсөн. Мөн Уурын зуухны 2 ам галладаг бөгөөд 1 зуух цоорсон хэдэн жил удаа дараа нөхөж, гагнаж аргалж ирсэн боловч цаашид аргацаах боломжгүй хүрээд байна. Мөн хичээлийн байрууд болон дотуур байр өвөлдөө зарим газраараа маш хүйтэн зарим ангид хичээл орох боломжгүйд хүрдэг учир мэргэжлийн байгууллагад хандаж сантехникийн үзлэг хийлгэхэд түлхэлтийн носос шаардлагатай гэсэн. Иймээс Уурын зуухны үнэ-18.000.000, Түлхэлтийн носос-2*3.500.000=7.000.000 нийт 25.000.000 төгрөг шаардлагатай байгаа.

3. Хүрэл соёмбо ХХК 60 сая төгрөгний Сургуулийн дотуур байрны дээврийн засварын ажил хийгдэж буйтай холбогдуулан Ажлын комисс томилон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн ажиллаж байна.

4. Сүхбаатар аймаг 2022 оны Шилдэг багш менежер шалгарсан Бага ангийн сургалтын менежер Ү.Ариунцэцэг Шилдэг багшаар Л.Энхээ, Т.Баярцэцэг нар шалгарлаа.

5. 2022-2023 оны хичээлийн жилийн "Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ хийх" үйл ажиллагааг "Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаалын 3.1-ийг үндэслэн СББ-ыг үнэлэх үнэлгээг зохион байгуулах, үр дүнг тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг захирлын тушаалаар байгуулан, Бумбаалай цэцэрлэгтэй хамтран 2022.09.13-наас 7 төрлийн чиглэлээр нийт 93 сурагч хамрагдлаа.

1. **Хүүхдийн цэцэрлэг: 1.** 2022-2023 оны хичээлийн жилд СӨБ-д нийт 360 хүүхдийг хамруулан, хамран сургалтын хувь 82.5 тай байна. Үүнээс ердийн бүлэгт 250 хүүхэд, хувилбарт сургалтанд 110 хүүхэд хамрагдсан. Сумын хэмжээний 4-5 настай бүх хүүхдийг 100% цэцэрлэгт хамруулсан.
2. Сумын ЭМТ-тэй хамтран ердийн бүлэгт суралцаж байгаа хүүхдүүдийг цагаан хорхойн шинжилгээнд 100% хамруулсан.
3. Судар эгшиглэн -2022 төсөлд оролцогч нар энэ сард "Шинжлэх ухаан", "Танин мэдэхүйн" чиглэлээр номоо уншиж, номын тэмдэглэлээ "Бумбаалайн уншигчид" групптээ оруулсан.
4. Аймгийн Нэгдсэн Эмнэлэгтэй урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ байгуулан 2022.08.29 нд багш, туслах багш, тогооч нийт 26 хүн шинжилгээнд хамрагдсан.
5. Энэ хичээлийн жилд сургуульд орсон 6 настай хүүхдүүдээс "Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлгээг" бага боловсролын менежер Ү.Ариунцэцэг, багш нарын хамт арга зүйч Т.Ариунчимэг,багш Т.Давааням нартай хамтран зохион байгуулж, үнэлгээг авсан.
6. Эрхлэгч Д.Ариунмөнх, арга зүйч Т.Ариунчимэг нар 2022.09.15-17 өдрүүдэд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан "Хүүхдийн үнэлгээний арга зүйн сургалтанд хамрагдсан. 9.20-нд уг сургалтаа багш нартаа зохион байгуулсан.
7. ISO14001 стандартад суурилсан, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжигч ОУ-ын эко-сургууль, цэцэрлэг хөтөлбөрийн 3 дахь сургалт 9 сарын 21,22 өдрүүдэд Байгаль Орчны Судалгаа Шинжилгээний Төв дээр онол, дадлага арга зүйгээр зохион байгуулагдсан сургалтанд байгууллагын эко зөвлөлийн баг хамрагдлаа.

8. Багш ажилчдынхаа орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Үзэсгэлэн худалдаа”-г зохион байгуулсан. Үүнд цэцэг, цагаан идээ, хүнсний ногоо, чацаргана, хоол зэргээр үзэсгэлэн гарган борлуулалт хийсэн.
9. Урд байрны коридорын засварын ажлыг ажилчдын хүчээр хийж гүйцэтгэсэн. Мөн хуучин хоёр өрөөний ханыг буулган нийлүүлж, номын сангаа томсгон, засварыг бүрэн хийж дуусгасан.
10. Хичээлийн 1-р байрны урд талд байсан хүүхдийн тоглоомын талбайг 2-р байрны зүүн талд шилжүүлэн байршуулсан.
11. Цэцэрлэг орчмын болон хуучин ангийн хашаанаас рашаантын нуур хүртэлх талбайн хогийг цэвэрлэсэн.

Соёл: УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 05 дугаар сард:

- Ирсэн бичиг - 5
- Явсан бичиг - 2
 - Хариутай бичиг – 1
 - Хугацаандаа явсан бичиг – 1
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

- 1.1 Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу 5 албан бичиг хүлээн авч хариутай 1 бичгийн хариуг барагдууллаа. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих аяны хүрээнд сумын нийтийн эзэмшлийн газарт 50 ширхэг модыг тарьж усалгаа хийж арчилгаа тордлогыг хийн ажиллаж байна.
- 1.2 Аймгийн Засаг даргын 06 тоот өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр бэлтгэл ажлыг хийж 09 сарын 25-ны өдрөөс халаалт өгөхөөр ажиллаж байна.
- 1.3 Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Илүү их уншья” Үндэсний бичиг үсэг –Номын баярын нэгдсэн арга хэмжээнд номын санч Б.Отгонтуяа оролцлоо.
- 1.4 Аймгийн Засаг даргын 2022 оны 09 сарын 14-ны А\496 тоот захирамжийн дагуу ТСДГ-ыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлыг хэсгийн Сумын Засаг даргын 2022 оны 09 сарын 21-ний өдрийн А\143 тоот захирамжаар сумын хэмжээнд тооллого зохион байгуулах ажлын хэсгийг томилон тооллого зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.
- 1.5 Аймгийн засаг даргаар ахлуулсан ажлын хэсгийн хөтөлбөр удирдамжийн дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг бэлтгэн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- 1.6 Соёлын ажилтны баярыг сумын Соёл урлагийн ажилтан, авьяастнуудыг оролцуулан зохион байгуулж үйл ажиллагаандаа 45 авьяастнуудыг хамруулан Соёлын орон зай арга хэмжээг хамтран зохион байгууллаа.
- 1.7 9-р сард соёл урлагийн нэгдсэн 7 арга хэмжээ, номын сангийн чиглэлээр 4 арга хэмжээ, соёлын өвийн чиглэлээр 3 арга хэмжээ гадны тоглолт түрээсийн арга хэмжээ 2, бусад байгууллага багийн арга хэмжээ 5 нийт 21 арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

9-р сард өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 550.0, түрээсийн орлого 250,0 нийт 800,000 төгрөгийг орлого төвлөрүүлэлтийг хийж нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулсан.9 сарын 20-нд төсвийн сарын хуваарийн санхүүжилтээ авч сарын гүйлгээг хийж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ТСДГ-ыг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэгч ХХК-аас комисс ажиллуулан хүлээн аваад байна. Тус ажлыг нийт 25 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Номын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд сумын ИТХ-аас 400,000 төгрөгөөр, Соёлын аялалыг ИТХ,ЗДТГ-аас 500,000 төгрөгийг зарцуулж ажиллаа

2.2

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1 Номын сангийн танхимын үйлчилгээгээр 225 иргэд, хүүхэд багачуудад 679 нэр төрлийн номоор, зөөврөөр 20 иргэнд 39 номоор нийт 245 иргэнд 781 номоор үйлчилсэн байна.

3.2 Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Илүү их уншья уриатай Номын баярын үйл ажиллагаанд номын санч оролцсон.

Мөн номын баярыг сумын ИТХ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулан номын баярын үйл ажиллагаанд 245 сурагч, 76 ард иргэд оролцож, номын баярын үеэр тэмцээн уралдаан зохион байгуулан идэвхитэн 2 уншигчид Нацагдорж тэмдэгтэн шагналаар шагнаж урамшууллаа.

Хөдөөгийн багийн иргэдэд номын сангийн явуулын үйлчилгээг 1 удаа зохион байгуулан 67 иргэнд 150 ширхэг номоор үйлчиллээ.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1 ЕБС-ийн сурагчдын дунд Монгол наадгай уралдааныг номын баяртай хамтатган зохион байгуулан ажиллаа.

4.2 Орон нутаг судлах танхимын тохижилтын ажлын зургийг гаргуулж орон нутгийн хөгжлийн сангийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр тохижилтын ажил эхлээд байна.

Сумын ИТХ, ЕБС-тай хамтран Автобустай соёлын аялалыг зохион байгуулан ахлах ангийн 30 сурагчдыг хамруулан маршрутын дагуу зохион байгуулан ажиллаа.

4.3 Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Сумын хэмжээнд ТСДГ-ын улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг Сумын Засаг даргын А\143 тоот захирамжаар томилон бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1 Бүжгийн дугуйлан 45 сурагчтайгаар 5-р сард нийт 7 удаагийн 11 цагийн сургалтыг зохион байгуулан ардын бүжгийн дасгалыг жигдрүүлэн ардын 4 бүжиг, цэнгээнт 2 бүжиг зааж улирлын тайлангаа хамгаалан ажиллаа.

5.2 Хөгжмийн дугуйланд морин хуур 6, лимбэ 2, цахилгаан хөгжим 5, хуучир 2 нийт 15 сурагчид 10 өдрийн 18 цагийн сургалтанд хамрагдлаа

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

6.1 ЕБС-ийн сурагчдын дунд Монгол наадгай уралдааныг зохион байгуулан ажиллаа

6.2 ЕБС-ийн сурагчдын дунд “ Хүрэл тулга ” наадмыг зохион байгуулж нийт 18 сурагчид оролцлоо

6.5 Номын баяр нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа

6.6 ТСДГ-ыг сурталчлах зорилгоор Автобустай “Соёлын аялал”ыг зохион байгууллаа.

6.7 Хөдөөгийн 4 багт соёл урлагийн үйлчилгээг хүргэн ажиллаа.

6.8 Соёл урлагийн ажилтны баярыг “Соёлын орон зай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ.

6.9 Соёлын олон талт арга хэмжээнд нийт 980 гаруй үйлчлүүлэгчдийг хамруулсан байна.

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Эрүүл мэндийн чиглэлээр: 2022 оны 09 сарын 27 -ны байдлаар 29 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний:25 насанд хүрэгчид, 4 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 350, урьдчилан сэргийлэх үзлэг 115 байна.

Түргэн тусламжийн дуудлага 65 ирснээс алсын дуудлага – 8 , ойрын дуудлага 57 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан. Ард иргэдэд эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг явуулын байдлаар үзүүлэх арга хэмжээ тус суманд зохион байгуулагдаж давхардсан тоогоор 1500 орчим үзлэгт хамрагдсан байна.

Гурав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд бод 1938, бог 5354 бүгд 7292 мал хамруулсан. Бруцеллёзын вакцинд 76225, YATӨ-47568, Хонины цэцэг 75200, Шүлхий 38141 бүгд 237134 мянган мал эрүүлжүүлээд байна. Орон нутгийн ДХХ 59294, Цусан халдварт 21953, Шөвөг яр 16630, Галзуу 4697, Томуу 3680 нийт 113546 мал эрүүлжүүлсэн.

Ариутгал халдваргүйтгэлийг 216.1 м2 талбайд хийгдсэн.

Мал сүргийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалганд 9657, угаалганд бод 5956, бог 96581, туулгалтанд бод 826, бог 8200, нохой 631, боловсруулалтанд бод 7694, бог 9610 нийт 129498 мал эрүүлжүүлж цахимд бүртгэгдээд байна.

Хавар шүлхийн вакцинжуулалтанд бод 33578, бог 4563 бүгд 38141 мал хамруулсан. Намрын вакцинжуулалт хийх бэлтгэл ажил хийгдэж байна.

Дөрөв: Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

2022 оны 09 сарын 12-ны өдрийн А/139 тоот захирамжаар “Ажлын хэсэг шинэчлэн” байгуулж “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнөөр тарьсан модонд хяналт мониторинг хийж ажилласан. Тус сумын хэмжээнд 4297ш мод тарьсанаас 4069ш мод ургаж сумын хэмжээнд 94.6 хувийн ургалттай байна. 10:8 харьцаатай хүлэмжинд үрээр тарьсан голтбор, агч, хайлаас 100% ургасан байна.

Тус сумын одоогийн байдлаар идлэг шонхор шувууны 1 отог байрласан. 7-н гэрээ хийгдэж үүнээс 4ш шонхорын актыг бичсэн. Баруун урт сумын 8-р багийн иргэн н.Будын өгсөн гомдлын дагуу отог байрласан газрын хог хаягдлыг цэвэрлүүлж ажилласан. Засаг даргын орлогч, Цагдаагийн тасгийн дарга, Багийн дарга миний бие 2 удаа хяналт шалгалтыг хийж шатах тослох материалын 77200 төгрөгийн зардал гарсан.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.

